



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/535

Баруун-Урт сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баруун-Урт сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Т.Нарантуяа захиралтай “Наран дөрвөлж” ХХК-ийн “Дөрвөлж” хүнсний дэлгүүр, Мөнххаан сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Доржготов захиралтай “Баянбүрэн цогт” ХХК-ийн “Баянбүрэн” хүнсний дэлгүүр, Мөнххаан сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Доржготов захиралтай “Баянбүрэн цогт” ХХК-ийн “Оргих” хүнсний дэлгүүр, Баяндэлгэр сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Э.Эрдэнэцэнд захиралтай “Дархан бадрах өргөө” ХХК-ийн “Их-Өргөө” хүнсний дэлгүүр, Онгон сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Сүх захиралтай “Чандмань онгон оргил” ХХК-ийн “Оргил” мини маркет хүнсний дэлгүүр, Уулбаян сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй С.Дуламсүрэн захиралтай “Орлой баян зээрд” ХХК-ийн “Эрдэнэ-Оргих” хүнсний дэлгүүр, Дарьганга сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Т.Баяраа захиралтай “Дарьганга энгүй тал” ХХК-ийн “Шинэ сонголт” хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Октябрь захиралтай “Ашид оргих өлзийт очир” ХХК-ийн “Очир” хүнсний дэлгүүрүүдийн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай сунгаж, Түмэнцогт сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Д.Саруул захиралтай “Үргэлж жаргал” ХХК-ийн “Тамир-2” хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй М.Төртогтох захиралтай “Талын гэгээн тал” ХХК-ийн “Гэгээ” хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ц.Хүдэрчулуун захиралтай “Гэгээн Ингүмэл” ХХК-ийн “Гэгээн-Од” хүнсний дэлгүүрт өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл сунгагдсан болон шинээр олгогдсон аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн

2222011074

хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Энхцэцэг), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Гантулга), Мэргэжлийн хяналтын газар (С.Нямжав), Стандарт хэмжил зүйн хэлтэс (Д.Эрдэнэбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг дээрх аж ахуй нэгжүүдийн захирлуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

A red rectangular official stamp is centered on the page. It contains a handwritten signature in black ink that reads "М.ИДЭРБАТ". The stamp also contains some faint, illegible text in Mongolian script.

М.ИДЭРБАТ